

ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хэнтий аймгийн Харгуй ТӨХК-ийн 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ХЭА-2025/003/НА-СТА-ТӨҮГ

Чингис хот 2025 он	Дарга, тэргүүлэх аудитор: Ж.Ганбаатар Утас: 70562112 Цахим хаяг: khentii@audit.gov.mn Аудитын менежер: Д.Оюунтуяа Утас: 99775390 Цахим хаяг: oyuntuyad@audit.gov.mn Аудитор: Н.Туяа Утас: 99799709 Цахим хаяг: tuyan@audit.gov.mn Цахим хаяг: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a>
-----------------------	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

# 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



## ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

23119 Хэнтий аймаг, Хэрлэн сум, Сариг баг  
Утас:70-56-21-12, Факс: 70-56-21-12  
E-mail: khentii@audit.gov.mn

2025.03.13 № 346  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

ХЭНТИЙ АЙМГИЙН ХАРГУЙ ТӨХК-  
НИЙ ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ  
Г.ТӨМӨРБААТАР ТАНАА

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Харгуй ТӨХК-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Харгуй ТӨХК-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Монгол Улсын Засгийн газрын “Авто замын засвар арчлалтын компаниудыг өөрчлөн зохион байгуулах зарим арга хэмжээний тухай” 2023 оны 220 дугаар тогтоолын дагуу төрийн өмчит 20 компанийг нийлүүлэн “Авто замын засвар арчлалтын нэгтгэл” ТӨХК -ийг байгуулж, Харгуй ТӨХК-ийг охин компани болгон өөрчлөн зохион байгуулсан байна.

Тус байгууллага нь тайлант онд борлуулалтаас 3,885,475.9 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, борлуулсан бүтээгдэхүүний өртөгт 3,007,989.9 мянган төгрөг, ерөнхий удирдлагын зардалд 768,825.4 мянган төгрөг, бусад зардалд 234,068.7 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Тайлант онд улсын чанартай зам засвар, арчлалтын 5 ажлыг гүйцэтгэж 2,130,699.9 мянган төгрөг, орон нутгийн чанартай зам засвар, арчлалтын 12 ажлыг гүйцэтгэж 1,304,294.5 мянган төгрөг, бусад ажил үйлчилгээнээс 431,638.6 мянган төгрөг, банкны хүүгээс 460.5 мянган төгрөгийн орлогыг тус тус төвлөрүүлж, 449,643.1 мянган төгрөгийн авлагатай байна.

### Аудитын гол асуудал

Санхүүгийн тайлангийн аудитаар зөрчил илрээгүй. Аудитын явцад цалингаас суутгасан хувь хүний орлогын албан татварыг 2,702.3 мянган төгрөгөөр илүү шилжүүлсэн алдаа илэрснийг санхүүгийн тайланд авлагаар тусгуулсан.

232520846

### **Бусад асуудлын хэсэг**

“Авто замын засвар арчлалтын нэгтгэл” ТӨХК-ийн гүйцэтгэх захирлын тушаалаар “Авто замын засвар арчлалтын нэгтгэл” ТӨХК-ийн охин компани “Харгуй” ТӨХК-ийн 2024 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг батлан, тайлант оны цэвэр ашгийг 919.5 мянган төгрөгөөр тогтоосныг биелүүлээгүй 125,454.2 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно

### **Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ж.ГАНБААТАР

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/ төгрөгөөр /

	Балансын үзүүлэлт	2024 оны 01-р сарын 01	2024 оны 12-р сарын 31
1.1.1	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	5,454,770.03	262,594,765.68
1.1.2	Дансны авлага	1,171,580,692.86	449,643,106.25
1.1.3	Татвар, НДШ - ийн авлага	0.00	3,702,347.65
1.1.4	Бусад авлага	201,728.00	201,728.00
1.1.6	Бараа материал	208,514,101.98	264,199,848.10
<b>1.1.11</b>	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>1,385,751,292.87</b>	<b>980,341,795.67</b>
1.2.1	Үндсэн хөрөнгө	3,484,072,897.73	3,216,281,150.33
1.2.2	Биет бус хөрөнгө	148,770,000.00	155,447,248.48
<b>1.2.10</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>3,632,842,897.73</b>	<b>3,371,728,398.81</b>
<b>1.3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>5,018,594,190.61</b>	<b>4,352,070,194.49</b>
2.1.1.1	Дансны өглөг	376,347,400.00	-0.00
2.1.1.3	Татварын өр	150,425,633.07	1,633,363.25
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	6,598,571.00	0.00
2.1.1.1 3	Богино хугацаат өр төлбөрийн дүн	533,371,604.07	1,633,363.24
<b>2.2</b>	<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>533,371,604.07</b>	<b>1,633,363.24</b>
2.3.1	Өмч: - төрийн	436,426,000.00	436,426,000.00
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	171,465,655.46	171,465,655.46
2.3.8	Эзэмшигчдийн өмчийн бусад хэсэг	3,658,892,867.20	3,658,892,867.20
2.3.9	Хуримтлагдсан ашиг	218,438,063.88	83,652,308.59
<b>2.3.11</b>	<b>Эзэмшигчдийн өмчийн дүн</b>	<b>4,485,222,586.54</b>	<b>4,350,436,831.25</b>
<b>2.4</b>	<b>Өр төлбөр ба эзэмшигчдийн өмчийн дүн</b>	<b>5,018,594,190.61</b>	<b>4,352,070,194.49</b>

### 2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

/ төгрөгөөр /

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	Борлуулалтын орлого (цэвэр)	6,208,721,314.6 4	3,866,633,017.8 5
2	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	5,226,765,275.9 2	3,007,989,945.4 7
<b>3</b>	<b>Нийт ашиг (алдагдал)</b>	<b>981,956,038.72</b>	<b>858,643,072.37</b>
4	Түрээсийн орлого	0.00	0.00
5	Хүүгийн орлого	1,128,044.78	460,497.80
6	Мал аж ахуйн орлого	0.00	0.00
7	Эрхийн шимтгэлийн орлого	0.00	0.00
8	Бусад орлого	0.00	18,382,400.00
9	Борлуулалт, маркетингийн зардал	0.00	0.00
10	Ерөнхий ба удирдлагын зардал	761,470,821.30	768,825,408.98
11	Санхүүгийн зардал	49,938,955.73	0.00
12	Бусад зардал	100,205,518.71	234,068,736.70
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	0.00	0.00
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	0.00	0.00
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	0.00	0.00
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)	0.00	0.00
17	Бусад ашиг (алдагдал)	0.00	0.00
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	71,468,787.75	-125,408,175.50

19	Орлогын татварын зардал	9,258,609.53	46,049.79
20	Татварын дараах ашиг (алдагдал)	62,210,178.22	-125,454,225.29
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг алдагдал	0.00	0.00
<b>22</b>	<b>Тайлант үеийн цэвэр ашиг алдагдал</b>	<b>62,210,178.22</b>	<b>-125,454,225.29</b>
23	Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	0.00
	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	0.00	0.00
	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.00	0.00
	Бусад олз (гарз)	0.00	0.00
24	Орлогын нийт дүн	0.00	0.00
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	0.00	0.00

### 2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	НИЙТ ДҮН
<b>2023 оны 1-р сарын 1- ний үлдэгдэл</b>	436,426,000.00	171,465,655.46	3,375,149,839.44	156,227,885.67	4,116,249,322.72
Бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00
Залруулсан үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00	0.00
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	0.00	62,210,178.21	62,210,178.21
Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	0.00	0.00	0.00	0.00
Өмчид гарсан өөрчлөлт	0.00	0.00	283,743,027.76	0.00	283,743,027.76
Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00		
Дахин үнэлгээний нэмэгдэл	0.00	0.00	0.00	0.00	0.00
<b>2024 оны 01-р сарын 01- ний үлдэгдэл</b>	<b>436,426,000.00</b>	<b>171,465,655.46</b>	<b>3,658,892,867.20</b>	<b>218,438,063.88</b>	<b>4,485,222,586.54</b>
Бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00
Залруулсан үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00	0.00
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	0.00	-125,454,225.29	-125,454,225.29
Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	0.00	0.00	0.00	0.00
Өмчид гарсан өөрчлөлт	0.00	0.00		0.00	0.00
Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	-9,331,530.00	-9,331,530.00
Дахин үнэлгээний нэмэгдэл	0.00	0.00	0.00	0.00	0.00
<b>2024 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	436,426,000.00	171,465,655.46	3,658,892,867.20	83,652,308.59	4,350,436,831.25

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/ төгрөгөөр /

Мөрийн дугаар		Өмнөх он	Тайлант он
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	0.00	0.00
<b>1.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>6,452,210,453.09</b>	<b>4,992,285,982.87</b>
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	6,265,104,036.00	4,883,684,758.87
	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	0.00	0.00
	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	0.00	0.00
	Буцаан авсан албан татвар	0.00	0.00
	Татаас, санхүүжилтийн орлого	0.00	0.00
	Бусад мөнгөн орлого	187,106,417.09	108,601,224.00
<b>1.2</b>	<b>Мөнгөн зарлага (-)</b>	<b>6,193,306,946.39</b>	<b>4,724,476,955.02</b>
	Ажиллагчдад төлсөн	858,886,638.00	933,565,428.00
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн мөнгө	266,379,790.70	286,979,707.31
	Бараа материал худалдан авахад төлсөн	1,916,709,130.45	1,179,436,484.50
	Ашиглалтын зардалд төлсөн	69,773,661.21	59,451,863.93
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	1,641,773,073.24	1,027,853,556.00
	Хүүгийн төлбөрт төлсөн	45,778,865.32	0.00
	Татварын байгууллагад төлсөн	243,660,413.26	438,002,283.04
	Даатгалын төлбөрт төлсөн	8,284,680.00	8,439,975.00
	Бусад мөнгөн зарлага	1,142,060,694.21	790,747,657.24
<b>1.3</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>258,903,506.70</b>	<b>267,809,027.85</b>
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	0.00	0.00
<b>2.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>1,128,044.78</b>	<b>460,497.80</b>
	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	0.00	0.00
	Биет бус хөрөнгө борлуулсны орлого	0.00	0.00
	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого	0.00	0.00
	Хүлээн авсан хүүгийн орлого	1,128,044.78	460,497.80
	Хүлээн авсан ногдол ашиг	0.00	0.00
<b>2.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>267,041,286.20</b>	<b>1,798,000.00</b>
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	267,041,286.20	0.00
	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	0.00	1,798,000.00
	Хөрөнгө оруулалт эзэмшихэд төлсөн	0.00	0.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-265,913,241.42	-1,337,502.20
<b>3</b>	<b>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
<b>3.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>390,000,000.00</b>	<b>0.00</b>
	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	390,000,000.00	0.00
<b>3.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>390,000,000.00</b>	<b>9,331,530.00</b>
	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	390,000,000.00	0.00
	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	0.00	0.00
	Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн	0.00	0.00
	Төлсөн ногдол ашиг	0.00	9,331,530.00
<b>3.3</b>	<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>0.00</b>	<b>-9,331,530.00</b>
<b>4</b>	<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>-7,009,734.72</b>	<b>257,139,995.65</b>
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	12,464,507.75	5,454,770.03
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	5,454,770.03	262,594,765.68

### 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар 2,702.3 мянган төгрөгийн 1 алдаа илэрснийг санхүүгийн тайланд залруулсан. Үүнд:

Аудитын явцад цалингаас суутгасан хувь хүний орлогын албан татварыг 2702347.65 төгрөгөөр илүү шилжүүлсэн алдаа илэрснийг санхүүгийн тайланд авлагаар тусгуулав.

Аудитаар зөрчил илрээгүй.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

### 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

#### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Татварыг илүү шилжүүлсэн	1	2,702.3			1	2,702.3	1	2,702.3				
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>2,702.3</b>			<b>1</b>	<b>2,702.3</b>	<b>1</b>	<b>2,702.3</b>				